

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР**  
**БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ,**  
**АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**  
**ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**  
*/2024 оны байдлаар/*

2024 оны 12 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Улс, нийслэлийг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт шинжилгээ үнэлгээг хийв.

Тус газарт хамаарах бодлогын баримт бичигт тусгагдсан үндсэн хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэх нийт 9 арга хэмжээ байна.

Үүнээс:

Үндсэн хэрэгжүүлэх – 2

Хамтран хэрэгжүүлэх - 7

2024 оны байдлаар бодлогын баримт бичигт тусгагдсан үндсэн хэрэгжүүлэх болон хамтран хэрэгжүүлэх нийт 9 арга хэмжээний хэрэгжилт 95.6 хувийн биелэлттэй буюу зорилт арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

Үүнээс үндсэн хэрэгжүүлэх 2 арга хэмжээний хэрэгжилт 90 хувь, хамтран хэрэгжүүлэх 12 арга хэмжээний хэрэгжилт 97.5 хувийн биелэлттэй байна.

**Хүснэгт №1 Бодлогын баримт бичгийн арга хэмжээний хэрэгжилт**

№	Бодлогын баримт бичиг	Арга хэмжээ /тоо/		Хэрэгжилтийн хувь	Тайлбар
		ХСХГ	ХШГ		
1	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	4	1	100	Хамтран хэрэгжүүлэх 1 арга хэмжээ
2	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	5	2	95	Хамтран хэрэгжүүлэх 2 арга хэмжээ
3	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	8	4	97.5	Хамтран хэрэгжүүлэх 4 арга хэмжээ
4	Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө	6	2	90	Үндсэн хэрэгжүүлэх 2 арга хэмжээ
<b>Нийт</b>		<b>28</b>	<b>9</b>	<b>95.6</b>	

2024 оны эхний хагас жилд газрын бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт орж "Хотын стандарт"-ын чиг үүрэг Хот байгуулалт, хотын стандартын газарт шилжсэнтэй холбогдуулан бодлогын баримт бичигт тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилтийг Хот байгуулалт, хотын стандартын газар хариуцан ажиллаж байна.

**Хүснэгт №2 Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ**

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилтийн хувь	Тайлбар
---	-------------	-------------------------	-------------------	---------

<b>НЭГ. “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>				
1	Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлнэ.	ХБХГ, НОСБГ, НОСК, ХСХГ	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
2	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт орчны стандарт мөрдүүлнэ.	ХСХГ	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
3	Хотын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулна.	ХБХГ, ХСХГ, НОБГ	100	Хамтран хэрэгжүүлэх
4	Хотын нэгдсэн стандартыг боловсруулж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх тогтолцоог бий болгоно.	ХСХГ	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
<b>Хамтран хэрэгжүүлэх: 1 арга хэмжээ</b>				
<b>ХОЁР. НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ</b>				
1	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлсэн байна.	НЗДТГ, ХСХГ	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
2	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих зөвшөөрлийг иргэд, олон нийтэд нээлттэй болгосон байна.	НХБХГ, НГЗБА, ХСХГ, НМТГ	90	Хамтран хэрэгжүүлэх
3	Хот төлөвлөх, байгуулах үйл ажиллагаанд мөрддөг стандартыг хангуулах шаардлагуудыг боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	ХСХГ	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
4	Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	НХБХГ, НМХГ, НШУУИГ, ХСХГ	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
5	Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна	ХСХГ	100	Хамтран хэрэгжүүлэх
<b>Хамтран хэрэгжүүлэх: 2 арга хэмжээ</b>				
<b>ГУРАВ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР</b>				
1	Иргэд, олон нийтэд биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, амарч зугаалах тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор стандартад нийцсэн спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулна.	УБЗАА, ХСХГ, Дүүргүүд	100	Хамтран хэрэгжүүлэх

2	Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага”, “Хөв цөөрөм үүсгэх болон хур тундасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага” хотын стандартыг боловсруулж, мөрдүүлнэ.	ХСХГ, УСУГ НБОГ	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
3	“Орон сууцны хороолол дахь ногоон байгууламжийн техникийн ерөнхий шаардлага” хотын стандартыг боловсруулж, мөрдүүлнэ.	ХСХГ, УБЗАА	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
4	“Хот доторх оршуулгын газрын орчны эрүүл аюулгүй байдлын ерөнхий шаардлага” хотын стандартыг боловсруулж, мөрдүүлнэ.	ХСХГ, УБЗАА	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
5	“Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх ерөнхий шаардлага, удирдамж арга зүйн баримт бичгийн төслийг батлуулсан байна.	ХСХГ, НБОГ	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
6	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих зөвшөөрлийг иргэд, олон нийтэд нээлттэй болгосон байна.	НХБХГ, НГЗБА ХСХГ НМТГ	90	Хамтран хэрэгжүүлэх
7	Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрдөх, хотын стандартыг боловсруулж, мөрдүүлнэ	ХСХГ	100	Хамтран хэрэгжүүлэх
8	Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилгыг хүртээмжтэй дэд бүтцийн стандартад нийцүүлнэ.	НОСК ХСХГ НХБХГ	100	Хамтран хэрэгжүүлэх

**Хамтран хэрэгжүүлэх: 4 арга хэмжээ**

**ДӨРӨВ.НИЙСЛЭЛИЙН 2024 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1	Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулах	ХСХГ, хяналтын чиг үүрэг бүхий бусад байгууллагууд	90	Үндсэн хэрэгжүүлэх
2	Ногоон байгууламж бүлгийн хотын стандартыг мөрдүүлэх	УБЗАА, ХСХГ, Дүүргүүдийн ЗДТГ	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
3	Хог хаягдлын менежмент бүлгийн хотын стандартыг мөрдүүлэх	УБЗАА, ХСХГ, Дүүргүүдийн ЗДТГ	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
4	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн системийг бүрэн ашиглалтад оруулах /барилга, байгууламжийн хяналт эрсдэлийн удирдлагын дэд системтэй/	ХСХГ	90	Үндсэн хэрэгжүүлэх
5	Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх	УБЗАА, ХСХГ, ХБХГ, НГЗБА, Дүүргүүдийн ЗДТГ	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн
6	Улаанбаатар хотын өндөржилтийн зураглалын баримт бичгийг хот төлөвлөлт, байгуулалтын үйл ажиллагаанд мөрдөх, гүйцэтгэлд	УБЗАА, ХБХГ, ХСХГ, НЗХГ, НБОГ, НГЗБА	-	ХБХСГ-т чиг үүрэг шилжсэн

нэгдсэн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	Төвийн 6 дүүрэг		
<b>Үндсэн хэрэгжүүлэх: 2 арга хэмжээ</b>			

Цаашид бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн үр нөлөө, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг товч бөгөөд тодорхой тайлагнаж ажиллах шаардлагатай байна.

Мөн бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн байдалд сар бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, Нийслэлийн хяналт шинжилгээ үнэлгээний цахим системд тайлагнан хянаж баталгаажуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажилласан.

ХЯНАСАН:  
ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

НЭГТГЭСЭН:  
ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.МӨНХТУЯА

С.БОЛДОО

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН  
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН  
(Хяналт шалгалтын газар)

2024 оны 12 дугаар сарын 12

Улаанбаатар хот

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжих хугацаа	Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он)	Хүрсэн түвшин, үр дүн	Хувь	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
<b>ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ</b>						
<b>Зорилт 9.2. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.</b>						
1.	9.2.33. Хотын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулна.	2021-2030	-	1.Хот байгуулалт, хотын стандартын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу сургууль, цэцэрлэг, эмнэлгийн-7, нийтийн зориулалттай орон сууцны-11 нийт <b>18</b> барилгад Барилгын тухай хууль болон “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” БНБД 22.01.21-ийн холбогдох шаардлагуудыг хангаагүй, болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтыг хориглох тухай Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг Хот байгуулалт, хотын стандартын газарт хүргүүлсэн. 2.Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 126 дугаар тушаалаар батлагдсан “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ын дагуу Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Эдү апартмент хотхоны 207 дугаар байр, Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо Хонхор 16 айлын орон сууцны барилгуудад хяналт шалгалт хийж, Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, БНБД 22.01.21-ийн холбогдох шаардлагуудыг хангахгүй, болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй болсон талаарх Барилгын техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлт болон холбогдох материалыг Хяналт шалгалтын газрын	100%	ХБХСГ, ХШГ, НОБГ

1	2	3	4	5	6	7
				даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар хурлаар хэлэлцүүлж, ашиглалтыг хориглохоор шийдвэрлэсэн. Шийдвэрийг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/845 дугаартай албан бичгээр Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Орон сууцны корпораци, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт тус тус хүргүүлсэн.		

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЭНХБАЯР

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.МӨНХБАЯР


ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.МӨНХТУЯА

НЭГТГЭСЭН:

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.ГАЧМАА



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН  
(Хяналт шалгалтын газар)**

2024 оны 12 дугаар сарын 12

Улаанбаатар хот

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр сая төгрөг)	Нийт хөрөнгийн хэмжээ(сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтод 2024 он			Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
									Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (Сая.төг)	Төсвийн (Гүйцэтгэл		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	
<b>ТАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>													
<b>5.1 Нийслэлийн ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, хотыг цэцэрлэгжүүлэх, ойжуулах, тохижилт бүхий гудамж, талбайг бий болгож, иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.</b>													
1	5.1.2 Хотын тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.	209	5.1.2.1.Иргэд, олон нийтэд биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, амарч зугаалах тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг байгуулна.	2021-2024	УБЗАА ХСХГ Дүүргү үд	УНТ	21,7 45.7	Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбай 23.	Стандартад нийцсэн амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайг 9-өөр нэмэгдүүлсэн байна.	5,40 0.0	-	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас захиалагчийн хяналт хэрэгжүүлж ажилласан амралт, спорт, хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын ажлыг ашиглалтад оруулах тухай нийт 109 хүсэлтийг судалж, ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: - Амралтын талбайн тохижилт 8; - Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт 29; - 3*3 сагсан бөмбөгийн талбай 72.	100
<b>6.1. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрөлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ.</b>													
2	6.1.3.Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл	283	6.1.3.1.Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар	2022-2023	НХБХГ, НМТГ, НГЗБА, ХСХГ	НТ	400.0	-	-	-	-	-Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа, шинэчлэлтийг эрчимжүүлэх, ашиглалтад оруулах талаар Хот байгуулалт, хотын стандартын	90

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
	ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.		олгох, барилга барих үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй болгоно.									газар, Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар болон холбогдох байгууллагуудын хамтарсан 2 удаагийн уулзалтад оролцож, хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн хооронд холболт хийгдэхэд өгөгдөл, мэдээллүүдийн урсгалыг тодорхойлох үүднээс ашиглалтад орсон барилгын мэдээллийн сангийн бүрдэл, хэрэглээний талаар мэдээлэл боловсруулж 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Нийслэл Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн. -Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ээр барилга барих хүсэлтээ гаргахаас эхлээд архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргах зэрэг шат дараалсан үйл ажиллагааг цахимжуулахаас гадна инженерийн шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх ажлын үйл ажиллагааг цахимжуулж иргэн, хуулийн этгээд шийдвэрлэлтийн явцыг харах, хянах боломжтой болсон. Дээрх системд барилга барих зөвшөөрлийн хүсэлт-10210, эдээлэл бүртгэгдсэн барилга, байгууламж-23114, шугам сүлжээний зурган мэдээлэл-34730, тохижилт, ногоон байгууламжийн зурган мэдээлэл-12364, нийгмийн дэд бүтцийн зурган мэдээлэл-1906 бүртгэгдсэн ба хяналт шалгалтын ажилд нэвтрүүлэн ажиллаж эхэлсэн.	
3	6.1.5.Хотын стандарт, норм дүрмийг олон	297	6.1.5.1.Хот төлөвлөх, хот байгуулах үйл	2021-2024	ХСХГ	НТ	533.5	Хот төлөвлөх, хот	Стандартыг хангуулах 8 багц	122.0	-	Батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.		ажиллагаанд мөрддөг стандартыг хангуулах шаардлагуудыг боловсруулж мөрдүүлнэ.					байгуулах үйл ажиллагаанд мөрддөг стандартыг хангуулах 22 багц боловсруулсан.	шаардлагыг боловсруулсан байна.			тавих чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд: - Барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, хотын стандартын хэрэгжилтийг хангуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалтыг нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй Сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ)-дын нийт 478 төлөөллийг хамруулан зохион байгуулсан. - Барилга угсралтын орчны аюулгүй байдлыг хангуулаагүй 39 байршилд орчны хог хаягдал болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж, 43 байршилд барилгын түр хашааг стандартын дагуу солиулав. - Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явагдаж буй 392 байршилд хяналт шалгалт хийж, 1568 зөрчил илрүүлж, 158 шаардах хуудас, 16 мэдэгдэх хуудас, 21 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага, 105 дүгнэлт, 45 иргэн, хуулийн этгээдэд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, 24 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоосон. Хяналт шалгалтын хүрээнд зураг төсөл, барилгын ажлын зөвшөөрлийг олгохдоо хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах талаар тус газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн "Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлд хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах тухай" албан мэдэгдлийг Хот байгуулалт, хотын стандартын газарт болон Нийслэлийн орон сууцны	

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
												бодлогын газруудад тус тус хүргүүлсэн.	
4		298	6.1.5.2.Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилгыг хүртээмжтэй дэд бүтцийн стандартад нийцүүлнэ.	2022-2024	НОСК ХСХГ НХБХГ	-	-	Стандартад нийцсэн төрийн болон нийгмийн үйлчилгээний 40 барилга байна.	Төрийн болон нийгмийн үйлчилгээний 45 барилгыг стандартад нийцүүлсэн байна.	-	-	<p>1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналтын газрын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 02-00/02 дугаартай удирдамжийн хүрээнд төрийн болон олон нийт, нийтийн орон сууцны зориулалттай барилгын ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар барилга байгууламжийн орц, гарц, дотор зохион байгуулалт, гадна тохижилт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаагүй зөрчил дутагдал түгээмэл илэрч, төрийн болон орон сууц, олон нийтийн зориулалттай барилгын эзэмшигч өмчлөгч, ашиглагчдад улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн. Үр дүнд нийтийн үйлчилгээний болон олон нийтийн 47 барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг хууль, норм ба дүрэм стандартад нийцүүлэв.</p> <p>2. Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" А/503 дугаар захирамжийн дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах дараах 3 байгууллагын төлөөллийг тогтмол оролцуулж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо;</li> </ul>	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
											<ul style="list-style-type: none"> <li>- Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо;</li> <li>- Хан-Уул дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо.</li> </ul> 2024 оны байдлаар нийслэлийн хэмжээнд нийт 336 барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг стандарт, норм дүрмийн дагуу хангуулах чиглэлээр барилгын захиалагч, гүйцэтгэгчдэд үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулж ажиллав.	
<b>Биелэлтийн дундаж үнэлгээ</b>												<b>97.5</b>

ТАНИЛЦСАН:  
 ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:  
 ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН  
 АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

НЭГТГЭСЭН:  
 ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН  
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



С.ЭНХБАЯР

Б.МӨНХБАЯР

Б.МӨНХТУЯА

М.ГАЧМАА

**“НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ” ДУНД ХУГАЦААНЫ  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

(Хяналт шалгалтын газар)

2024 оны 12 дугаар сарын 12

Улаанбаатар хот

№	Бодлогын зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Батлагдсан төсөв	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая тагалагдсан)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7	8	9	
1	9.3. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн, иргэд, олон нийтэд нээлттэй болгоно.	9.3.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих зөвшөөрлийг иргэд, олон нийтэд нээлттэй болгосон байна.	2021-2025	-	-	Газар олгох, барилга барих зөвшөөрлийг цахимжуулах систем	<p>- Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа, шинэчлэлтийг эрчимжүүлэх, ашиглалтад оруулах талаар Хот байгуулалт, хотын стандартын газар, Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар болон холбогдох байгууллагуудын хамтарсан 2 удаагийн уулзалтад оролцож, хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн хооронд холболт хийгдэхэд өгөгдөл, мэдээллүүдийн урсгалыг тодорхойлох үүднээс ашиглалтад орсон барилгын мэдээллийн сангийн бүрдэл, хэрэглээний талаар мэдээлэл боловсруулж 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Нийслэл Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн.</p> <p>- Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ээр барилга барих хүсэлтээ гаргахаас эхлээд архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажлыг эхлүүлэх,</p>	90	НХБХГ, НГЗБА, ХСХГ, НМТГ

	1	2	3	4	5	6	7	8	9
							<p>үргэлжлүүлэх зөвшөөрөл, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргах зэрэг шат дараалсан үйл ажиллагааг цахимжуулахаас гадна инженерийн шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх ажлын үйл ажиллагааг цахимжуулж иргэн, хуулийн этгээд шийдвэрлэлтийн явцыг харах, хянах боломжтой болсон. Дээрх системд барилга барих зөвшөөрлийн хүсэлт-10210, эдээлэл бүртгэгдсэн барилга, байгууламж-23114, шугам сүлжээний зурган мэдээлэл-34730, тохижилт, ногоон байгууламжийн зурган мэдээлэл-12364, нийгмийн дэд бүтцийн зурган мэдээлэл-1906 бүртгэгдсэн ба хяналт шалгалтын ажилд нэвтрүүлэн ажиллаж эхэлсэн.</p>		
2	<p>9.5. Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.</p>	<p>9.5.3 Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна.</p>	2021-2025	-	-	Хотын стандартын баримт бичиг	<p>- Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу барилга, дэд бүтцийн чиглэлээр нийт 227 иргэн, ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар барилгын түр хашааг стандартад нийцүүлэх, орчны аюулгүй байдлыг хангуулах үүрэг даалгавар өгч, буулгах барилга 25, нийтийн эзэмшилд шилжүүлэх шаардлагатай 38 байршлын судалгааг гаргасан. Нийтийн эзэмшлийн зам талбайд хууль тогтоомж, стандарт норм зөрчсөн зөрчлийн судалгааг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/302 дугаартай албан бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Хууль тогтоомж, хотын стандартыг мөрдүүлэх талаар авах зарим арга</p>	100	ХСХГ


1	2	3	4	5	6	7	8	9
						<p>хэмжээний тухай” А/367 дугаар захирамжийн хүрээнд 43 байршилд барилгын түр хашааг стандартын дагуу солиулж, худалдаа, үйлчилгээний байгууллагуудын гадна хаягийн стандарт хангуулаагүй, өнгө үзэмжгүй нийт 389 зөрчил илрүүлж, 203 газрын гадна хаягийг газар дээр нь буулгуулав.</p> <p>- Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “Хууль, тогтоомж, норм ба дүрэм, стандартын хэрэгжилтэд шуурхай арга хэмжээ авах, зөрчлийг арилгуулах тухай” удирдамжийн дагуу нийслэлийн төвийн дүүргүүдийн 18 ерөнхий боловсролын сургууль, 18 цэцэрлэгийн гадна орчны аюулгүй байдлын талаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулсан. Стандарт зөрчсөн сургууль, цэцэрлэгт зөвлөмж мэдээлэл хүргэж, гадна тохижилт, хашаа хайс, хаягийн байгууламж, гэрэлтүүлэг, тоглоомын талбайг хотын стандартад нийцүүлэх, аюулгүй байдлыг хангуулах талаар мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа.</p>		
<b>Биелэлтийн дундаж үнэлгээ</b>								<b>95%</b>

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



С.ЭНХБАЯР

Б.МӨНХБАЯР

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.МӨНХТУЯА

НЭГТГЭСЭН:  
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



М.ГАЧМАА

НИЙСЛЭЛИЙН 2024 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН  
(Хяналт шалгалтын газар)

2024 оны 12 дугаар сарын 12

Улаанбаатар хот

Д/д	Бодлогын үндэслэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Суурь түвшин		Санхүүжилт сая төгрөг	Хариуцагч	Хэрэгжилт	Хувь
				Он	Түвшин				
1	2	3	4	5	6	7	8	9	10
203	АХ-5.2.14, 9.4.2 НХТЖҮЧ-5.1	Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулах	Хувь	2022	-	НТ 200.0	<b>ХСХГ</b> , хяналтын чиг үүрэг бүхий бусад байгууллагууд	Барилга, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, хяналтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, төрийн бус байгууллага, олон нийтийн хамтын хяналтын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын давхардлыг арилгаж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор "Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулах" ажлын хэсгийг Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны А/30 дугаар тушаалаар байгуулж, хөтөлбөрийн хүрээнд 5 зорилт, 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төслийг боловсруулсан. Хөтөлбөрийн төслийг нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01/1005 дугаартай албан бичгээр хүргүүлж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулахаар танилцуулга, холбогдох шийдвэрийн төслийг хянуулж байна.	90%
297	АХ-9.3.1, НХТЖҮЧ- 9.3.3,	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн системийг бүрэн	Хувь	2022	30	НТ 150.0	<b>ХСХГ</b>	-Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа, шинэчлэлтийг эрчимжүүлэх, ашиглалтад оруулах талаар	90%

1	2	3	4	5	6	7	8	9	10
	НЗДҮАХ- 6.1.3	ашиглалтад оруулах /барилга, байгууламжийн хяналт эрсдэлийн удирдлагын дэд системтэй/ -Дэд систем ашиглалтад оруулах ажлын хэрэгжилт						<p>Хот байгуулалт, хотын стандартын газар, Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар болон холбогдох байгууллагуудын хамтарсан 2 удаагийн уулзалтад оролцож, хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн хооронд холболт хийгдэхэд өгөгдөл, мэдээллүүдийн урсгалыг тодорхойлох үүднээс ашиглалтад орсон барилгын мэдээллийн сангийн бүрдэл, хэрэглээний талаар мэдээлэл боловсруулж 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Нийслэл Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн.</p> <p>-Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ээр барилга барих хүсэлтээ гаргахаас эхлээд архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргах зэрэг шат дараалсан үйл ажиллагааг цахимжуулахаас гадна инженерийн шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх ажлын үйл ажиллагааг цахимжуулж иргэн, хуулийн этгээд шийдвэрлэлтийн явцыг харах, хянах боломжтой болсон. Дээрх системд барилга барих зөвшөөрлийн хүсэлт-10210, эдээлэл бүртгэгдсэн барилга, байгууламж-23114, шугам сүлжээний зурган мэдээлэл-34730, тохижилт, ногоон байгууламжийн зурган мэдээлэл-12364, нийгмийн дэд бүтцийн зурган мэдээлэл-1906 бүртгэгдсэн ба хяналт шалгалтын ажилд нэвтрүүлэн ажиллаж эхэлсэн.</p>	

1	2	3	4	5	6	7	8	9	10
332	АХ-9.2.34, 9.3.8, МУХТЖҮЧ- 2.5.2, 2.5.6, 9.3.1 МУЗГҮАХ- 3.7.12, НХТЖҮЧ- 9.14.1, НЗДУБХЗҮА Х-6.3.20	Улаанбаатар хотын өндөржилтийн зураглалын баримт бичгийг хот төлөвлөлт, байгуулалтын үйл ажиллагаанд мөрдөх, гүйцэтгэлд нэгдсэн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	Хувь	2023	-	-	УБЗАА, ХБХГ, ХСХГ, НЗХГ, НБОГ, НГЗБА Төвийн 6 дүүрэг	Улаанбаатар хотын өндөржилтийн зураглалын баримт бичгийн гүйцэтгэлд Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн дагуу Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын геодези зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагч хяналт шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Хяналт шалгалтын газарт дээрх чиглэлийн байцаагч байхгүй болно.	-
<b>Биелэлтийн дундаж үнэлгээ</b>									<b>90%</b>

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

НЭГТГЭСЭН:

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



С.ЭНХБАЯР

Б.МӨНХБАЯР

Б.МӨНХТУЯА

М.ГАЧМАА